
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга - Монгол Улсад

2019 оны 9 дүгээр сарын 19 - Дорнод аймаг





Дэлхийн санаачилга болох ОҮИТБС-д 55 орон нэгдсэнээс 52 орон л хэрэгжүүлж байна.

Манай Улс 2006 оноос эхлүүлж, 2010 онд “хэрэгжилтийн шаардлагад нийцсэн орон”, 2018 онд ОҮИТБС-ын стандартын “шаардлагыг хангасан орон”- оор үнэлэгдсэн.

Шаардлага хангасан орноор одоогоор Филиппин, Монгол, Зүүн Тимор, Сенегал, Колумб, Норвег, ХБНГУ, Нигери гэсэн 8 улс л хүлээн зөвшөөрөгдөөд байна.

2011 онд тайлангаа тогтвортой сайжруулж байгаа, 2016 онд цахим тайлагналыг амжилттай хэрэгжүүлсний учир ОҮИТБС-ын даргын шагналыг хүртсэн байна.

ОҮИТБС- ын стандарт нь эрдэс баялгийн салбарын үйл ажиллагааны шат бүрийг ил болгож, Компани, Засгийн газрын хариуцлагатай, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг төлөвшүүлэх зорилготой.

Тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах → Үйлдвэрлэл борлуулалт → Татвар, төлбөр, ноогдол ашиг → Төсөв, сан, орлогын хуваарилалт → Зарцуулалт, нийгмийн үр шим

Тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэл, борлуулалт, нийгэм, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төсөл, ажиллах хүч, байгаль орчны ил тод байдал, гэрээний ил тод байдал- 2021.01.01

Компаниуд төлснөө нийтлэдэг.

ЗГ орлогоо нийтэлдэг.

Улсын төсөв, хөгжлийн сан, орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдал,
төрийн өмчийн компаниудын төрийн эзэмшил, төсвийн шинжтэй зардлын ил тод байдал

Бенефицарь өмчлөгч- Ашиг хүртэгч эцсийн эзэмшлийн ил тод байдал-2020.01.01

2019 оны нэмэлт шаардлага- Жендерийн тэнцвэрт байдлыг хангах, төслийн түвшний тайлагнал, эрдсийн биржийн худалдааны орлогыг ил болгох







ОҮИТБС-ын олон талт оролцогч талуудын бүтэц (Засгийн газар, Компани, Иргэний нийгэм) нь ОҮИТБС- ын стандартын дагуу юуг хамруулахыг хамтран шийддэг.

Энэхүү бүтэц нь ОҮИТБС- ын нэгтгэл тайланг хөндлөнгийн этгээдээр гаргуулж, ил тод болгон хэвлэн нийтэлж, үнэлгээ хийлгэдэг.

Гарсан дүнг олон нийтэд хүргэж, мэдээлэл өгөх, хэлэлцүүлэх, баялгийн удирдлагыг сайжруулах талаар хамтарч ажиллана.

ОҮИТБС- МОНГОЛ ТӨРИЙН ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН БОДЛОГОД

УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоол “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай- 2025 он”:

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь **хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж**, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ.

Хоёр.Эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим

2.1.3.эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх;

2.1.6.улсын болон хувийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа **бүх шатны геологийн судалгаа, олборлолт, боловсруулалтын ажлын талаарх хуулиар хориглоогүй мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй байлгах;**

Гурав.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын чиглэл

3.1.Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд:

3.1.7.**ил тод байдлын** болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг **олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх;**

Дөрөв.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн

4.3.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн:

4.3.9.эрдэс баялгийн салбарын бүх шатны үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу явагдаж **олон нийтэд нээлттэй, ил тод байж**, шинээр хууль тогтоомж, журам боловсруулах, томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлэхэд олон нийтийн саналыг хүлээн авч, шийдвэр гаргахад тусгаж байх эрх зүйн орчин бүрдсэн байх;

ОҮИТБС- ТӨРИЙН БОДЛОГЫН БУСАД БАРИМТ БИЧИГТ

Нэг. УИХ-ын 2016 оны 19 дугаар тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”

- Зорилт 2. **Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж**, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Хоёр.УИХ-ын 2016 оны 51 дугаар тогтоол “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай”

- Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа
  - 4.1.6.Хувийн хэвшил дэх авилгын эрсдлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх
    - 4.1.6.5.**олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах**
- **ЗГ-ын 2017 оны 114 дугаар тогтоол “Төлөвлөгөө батлах тухай”**
  - **Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх**
  - Гэрээ, ашиг хүртэгч, БХГ-т талбайн байгаль орчин, нөхөн сэргээлт, Газрын тосны хайгуул, ашиглалт

Гурав.Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2-р сарын 6-ны өдрийн 42 дугаар тогтоол “Гурван тулгуурт хөгжлийн бодлого батлах тухай”

- 2.2. Бодлогын зорилт: Зорилт 5- Хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх;

ОУИТБС- ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ

УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”

- Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ: Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
  - 2.61.Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.

Монгол Улсын ЗГ-ын 2016 оны 121 дугаар тогтоол “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай”

- 2.61.Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.
  - **Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах, 2018 он**

Монгол Улсад ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд баримталж буй хууль эрх зүйн холбогдох заалтууд

Засгийн газар 2006 оны 1 тоот тогтоолоор ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргаж, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийг зохион байгуулж, эхлэлийг тавьж өгсөн.

- 2006 оны “Ашигт малтмалын тухай”хуулийн 48.10;
- 2009 оны “Цөмийн энергийн тухай” хуулийн 28.6.4;
- 2014 оны “Газрын тосны тухай” хуулийн 36.1;
- 2014 оны “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хуулийн 34.10;-заалтуудын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад тайланг гаргах үүргийг зохицуулж өгсөн.
- Засгийн газар 2007 онд 80 тоот тогтоол гаргаж, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын ОҮИТБС- ыг хэрэгжүүлэхтэй холбогдсон чиг үүргийг тодорхойлж өгсөн.
- Уг тогтоолыг 2012 оны 222, 2017 оны 263 тоот тогтоолуудаар шинэчилж ирсэн байна.
- 2017 оны 263 дугаар тогтоолоор ОҮИТБС-ын стандартыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн байна.
- 2017 оны 308 дугаар тогтоолоороо Монгол Улсын гишүүнчлэлийг баталж, жил бүрийн гишүүний татварыг төлөх болсон.
- 2018 онд 289 дүгээр тогтоол гаргаж, Үндэсний зөвлөлийн даргаар УУХҮ-ийн сайдыг, Ажлын хэсгийн ахлагчаар УУХҮЯ-ны ТНБД- ыг тус тус томилсон байна.
- Дэлхийн 70 гаруй орны Засгийн газар хоорондын “Нээлттэй засгийн түншлэл” ийн хүрээнд ОҮИТБС-ын шаардлага болох гэрээ, ашиг хүртэгч өмчлөл, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн ил тод байдлыг “Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-дөө оруулан, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Монголын ОУИТБС-ын бүтэц, зохион байгуулалт



Үндэсний зөвлөл – Удирдах дээд байгууллага- 2006 онд байгуулагдсан.

- Дарга: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд- **ЗГ-ын 2018 оны 289-р тогтоол**
- Гишүүд: УИХ, Засгийн газраас 10, компаниас 10, иргэний нийгмээс 10; Төв аймгийн ЗД - орон нутгийг төлөөлдөг.
- Нарийн бичгийн дарга: Ерөнхий сайдын ахлах зөвлөх
- Хуралдаан: Жилд 1-оос доошгүй удаа

Ажлын хэсэг – Зохицуулалтын үндсэн байгууллага- 2006 онд байгуулагдсан

- Ахлагч: Уул уурхай хүнд үйлдвэрийн төрийн нарийн бичгийн дарга -
- Гишүүд: Засгийн газраас 11, компаниас 11, иргэний нийгмээс 11; Сэлэнгэ аймгийн ЗДО -орон нутгийг төлөөлдөг.
- Нарийн бичгийн дарга: АА-ны зохицуулагч
- Хуралдаан: Улиралд 1-ээс доошгүй удаа

Ажлын алба – 2007 онд байгуулагдсан, өдөр тутмын хэрэгжилтийг зохион байгуулж, ЕС-ын АА, ДБ-ны хамтарсан төсөл хэлбэрээр ажиллаж байна. 2016 оноос Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын алба хэмээн нэрлэгдэх болсон.

- 2007- 2011он -2, 2012-2014 он -3, 2015 он- 4 орон тооны ажилтантай байна.

Монгол Улсын Засгийн газар, компани, иргэний нийгмийн хамтран ажиллах тухай санамж бичгийг 2007 оны 4 дүгээр сард байгуулсан байна.


ОҮИТБС- ын тайлагнал: Компани, Засгийн газар 2006-2018 он

ОҮИТБС-ын тайлан гаргасан компаниудын тоо	Засгийн газрын ОҮИТБС-ын тайланд орсон компаниудын тоо
2006 оны тайланг 64 компани 2007 оны тайланг 102 компани 2008 оны тайланг 113 компани 2009 оны тайланг 129 компани 2010 оны тайланг 268 компани 2011 оны тайланг 301 компани 2012 оны тайланг 1531 компани 2013 оны тайланг 1197 компани 2014 оны тайланг 990 компани 2015 оны тайланг 747 компани 2016 оны тайлангаа 1227 компани (2254 компани тайлагнах бүртгэлтэй байсан). 2017 оны тайлангаа 2225 компани гаргахаас 1489 гаргасан байна. 2018 оны тайлангаа 2139 компаниас 1486 компани гаргаад байна.	2006 оны тайланг 134 компани 2007, 2008 оны тайланг 184 компани 2009 оны тайланг 363 компани 2010 оны тайланг 478 компани 2011 оны тайланг 518 компани 2012 оны тайланг 1829 компани 2013 оны тайланг 1617 компани 2014 оны тайланг 1570 компани 2015 оны тайланг 1920 компани 2016 оны тайланг 2086 компани 2017 оны тайланг 2091 компани 2018 оны тайланг одоогоор 1986 компаниас орлого хүлээн авснаар 6 агентлаг, нийслэл, 8 дүүрэг, 13 аймаг тайлан гаргаад байна. (БОАЖЯ, МХЕГ, Сонгинохайрхан, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар аймаг тайлангаа гаргаагүй байна.)

Монголын ОУИТБС- ын нэгтгэл тайлангуудын товчоон 2006-2017 он

Дугаар	Он	Хэвлүүл-сэн он сар	Тайлан Гаргасан К^{o} –иуд	ЗГ-ын тайланд орсон К^{o} –иуд	Нэгтгэлийн босго USD	Нэгтгэлд орсон К^{o} – иуд	К^{o} –ийн төлбөр, сая USD	ЗГ-ын орлого, сая USD	Шийдэг-дээгүй Зөрүү, сая USD	Баталгаажуулагч/ Хараат бус хянан нэгтгэгч
1	2006	2008,05	64	134	140,000 дээш	25	351,6	333,7	2857,2	Крейн Уайт, Австрали
2	2007	2009,10	102	184	140,000 дээш	38	532,1	534,8	553,6	Эрнст Янг, Монгол, Малайз
3	2008	2010,05	113	184	70,000 дээш	46	490	489,7	300	Харт Нойрс, Улаанбаатар аудит, Их Британ, Монгол
4	2009	2011,06	129	363	35,000 дээш	101	526,7	526,7	41,5	Харт Нойрс, Улаанбаатар аудит,
5	2010	2012,01	268	478	35,000 дээш	150	910,7	910,7	0,3	Харт Нойрс, Улаанбаатар аудит,
6	2011	2012,11	301	518	28,000 дээш	200	1535,7	1535,7	53,6	Харт Нойрс, Улаанбаатар аудит,
7	2012	2013,12	1531	1829	28,000 дээш	200	1180,8	1180,8	266,8	Моорей Стефенс, Далайван аудит, Их Британ, Монгол
8	2013	2014,12	1197	1617	28,000 дээш	250	938,6	938,6	22	Харт Нойрс, Улаанбаатар аудит,
9	2014	2015,11	990	1570	125,000/50,000 дээш	236	1579,9 тэрбум төг	1582,2 тэрбум төг	581 сая төг	КейПиЭмЖи, Монгол, Франц
10	2015	2016,12	747	1920	100/150/50 сая төг дээш	202	1150,0 тэрбум төг	1432,9 тэрбум төг	112 сая төг	Харт Нойрс, Улаанбаатар аудит,
11	2016	2017,12	1227	2086	250/50/100/30 сая төг дээш	213	1073,0 тэрбум төг	1069,3 Тэрбум төг	74 сая төг	КейПиЭмЖи, Монгол, Франц
12	2017	2018,12	1489	2091	300/100-300/ сая төг/их бага/олб/хай	230	2363,3 тэрбум төг	2145,1 тэрбум төг	62 сая төг	Харт Нойрс, Улаанбаатар аудит,

Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын систем




Европын Сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр Монголын Интерактив ХХК, Олон улсын Адам Смит хүрээлэн хамтран 2014 оноос 2 үе шаттайгаар хэрэгжүүлж, ашиглалтанд оруулсан: www.e-reporting.eiti.mongolia.mn



Хамрах хүрээ:
1.ОУИТБС-ын тайлагнал-компанийн хэсэг
2.ОУИТБС-ын тайлагнал-Засгийн газрын хэсэг
3.Тайлангуудын нэгтгэлийн хэсэг
4. Тусгай зөвшөөрлийн газрын зураг, аймаг, сумаар г.м.-мэдээллийн хэсэг
5.Удирдлагын хэсэг

Гэрээний ил тод байдал



Гэрээний ил тод байдлын www.iltodgeree.mn цахим санг 2017 онд Нээлттэй нийгэм форум боловсруулж, ашиглалтад оруулсан. УУХҮЯ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан, ажиллаж байна. Одоогоор санд 426 гэрээ оруулсан байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн бичвэрүүдийг оруулсан.

Монголын ОҮИТБС-ын орон нутгийн дэд зөвлөлүүд



Засгийн газрын 2012 оны 222 –р тогтоолын дагуу байгуулагдсан. Бүх аймаг, нийслэл, уул уурхай бүхий дүүрэг сумдад байгуулагдах ёстой. Одоогоор нийслэл, 21 аймагт ОҮИТБС- ын дэд зөвлөлүүд, мөн 12 суманд буюу Өмнөговь аймгийн Цогтцэций, **Гурвантэс**, Төв аймгийн **Заамар**, Булган аймгийн Бүрэгхангай, Баянхонгор аймгийн Галуут, Дархан-Уул аймгийн Шарынгол, Хонгор, Хэнтий аймгийн **Бор-Өндөр**, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, **Ерөө**, Завхан аймгийн Дөрвөлжин, Дундговь аймгийн Өлзийт сумдад, 1 дүүрэг буюу Хан-Уул дүүрэгт дэд зөвлөл байгуулагдаад байна.

ОҮИТБС-ыг хэрэгжүүлсний үр дүн, үр нөлөө, ахиц дэвшил

Тайлан гаргаж байгаа нь компанийн хариуцлагатай байдал нэмэгдэж буйн бодит жишээ юм.

- ✓ 2006 онд анх 64 компани ОҮИТБС-ын тайлан гаргаж байсан бол 2017 оны тайлангаа 1489 компани гаргажээ. Тайлан гаргаж байсан компанийн тоо 20 дахин өссөн. Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа компаниудын тоо нэмэгдсэн.

Засгийн газраас тайлангаа саадгүй гаргаж байгаа нь хариуцлагатай байдал, манлайлал сайжирч байгаагийн илрэл юм.

- ✓ 2006 онд Засгийн газар 134 компаниас олборлох үйлдвэрлэлийн орлогыг хүлээн авсан тайлангаа гаргаж байсан бол 2017 оны тайлангаа 2202 компаниар тайлангаа гаргасан байна. Засгийн газрын тайланд хамрагдсан компаниудын тоо 15 дахин өсчээ. Засгийн газрын нэр хүнд өсч, улс орны хөгжлийн асуудлаар оновчтой шийдвэр гаргахад бодитой мэдээлэлтэй болж байна.

Бодитой мэдээллийн хүртээмж нэмэгдэж, ОҮИТБС-ын тайлагнал цахимжав.

- ✓ 2006-2013 он хүртэл Компани, Засгийн газар тайлангаа цаасаар гаргадаг байсан бол 2014 оноос эхлэн цахимаар гаргаж, Засгийн газар, Компанийн үнэт цаг, цаас, зардлыг хэмнэсэн тайлан болж байна.

Мэдээлэл хүртээмжтэй, ил тод, бодитой болсноор ашиглахад амар хялбар болж байна.

- ✓ Компанийн засаглалыг сайжруулах, үнэлгээ, судалгаа хийх, бодлогын шийдвэр гаргахад хэрэгтэй зүйл болж байна.

2019 онд хэрэгжүүлэх гол ажлуудаас дурдвал:

- Олон улсын “БДО” аудитын түншлэлээр Монголын ОҮИТБС-ын 2018 оны нэгтгэл тайланг хугацаанд нь ОҮИТБС-ын стандартын дагуу бэлтгүүлэн, хэвлэн нийтлүүлэх;
- ОҮИТБС-ын мэдээллийг системтэйгээр ил болгох, төсөл бүрээр ил тод тайлагнахыг эхлүүлэх:
  - Тайлан гаргадаг үүрэг бүхий төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулах, Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрийг гаргуулах;
- Ашиг хүртэгч эздийг ил тод болгох “Замын зураг” хөтөлбөрийг 2020 оны 1 дүгээр сарын 1- нээс өмнө хэрэгжүүлж, дуусгах:
  - Эрдэс баялгийн салбарын ил тод байдал, Ашиг хүртэгч эцсийн эздийн хуулийн төслүүдийг нэгтгэн ажлын хэсгийг УУХҮЯ дээр байгуулсан бөгөөд хуулийн төслийг боловсруулж, өргөн барьж батлуулах, зохицуулалтыг бий болгох;
- Засгийн газрын 289 дүгээр тогтоол гарсаны дагуу холбогдох өөрчлөлтийг оруулах:
  - Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн ажиллах журамд шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж өгөх;
- ОҮИТБС-ын шинэчлэгдсэн стандартын дагуу тайлагналын маягтыг шинэчлэх, холбогдох Компани, Засгийн газрын байгууллагуудын тайлан гаргагч ажилтнуудад сургах ажлыг зохион байгуулах;